

Шидэт дөрвөлжин IOI 96

Ноён Рубик рубикин шооны бодлогын хавтгайн хувилбарыг зохиосон бөгөөд шидэт дөрвөлжин гэж нэрлэжээ. Энэ нь 8 нүд бүхий тэгш өнцөгтөөс бүтнэ.

1	2	3	4
8	7	6	5

Энэ дөрвөлжингийн нүд бүр нь өөр өнгөтэй. Өнгүүд нь эхний эерэг 8 тоогоор тэмдэглэгдсэн. Шидэт дөрвөлжингийн харагдах байдал нь өнгүүдийн дарааллаар өгөгдөх бөгөөд өнгүүдийг тэгш өнцөгтийн зүүн дээд булангаас эхлэн цагийн зүүний дагуу дарааллуулан өгнө. Жишээ нь дээрхи зурган дахь хэлбэрийг 1,2,3,4,5,6,7,8 гэж өгнө. Энэ нь тоглоом эхлэх үеийн анхны хэлбэр юм.

Тоглогч 'A', 'B', 'C' үсгээр илэрхийлэгдэх үндсэн 3 хувиргалт хийж болно.

- 'A': дээд доод мөрийг солино.
- 'B': тэгш өнцөгтийг баруун тийш нэг удаа шилжүүлнэ.
- 'C': дунд талын 4 нүдийг цагийн зүүний дагуу нэг эргүүлнэ.

Доорхи зурагт анхны байрлалд байгаа шидэт дөрвөлжинг дээрхи 3 янзаар хувиргахад хэрхэн өөрчлөгдөхийг үзүүлээ.

A:	<table border="1"><tr><td>8</td><td>7</td><td>6</td><td>5</td></tr><tr><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td></tr></table>	8	7	6	5	1	2	3	4	B:	<table border="1"><tr><td>4</td><td>1</td><td>2</td><td>3</td></tr><tr><td>5</td><td>8</td><td>7</td><td>6</td></tr></table>	4	1	2	3	5	8	7	6	C:	<table border="1"><tr><td>1</td><td>7</td><td>2</td><td>4</td></tr><tr><td>8</td><td>6</td><td>3</td><td>5</td></tr></table>	1	7	2	4	8	6	3	5
8	7	6	5																										
1	2	3	4																										
4	1	2	3																										
5	8	7	6																										
1	7	2	4																										
8	6	3	5																										

Эдгээр үндсэн 3 хувиргалтаар бүх боломжит харагдацыг үүсгэж болно.

Анхы байрлалд байгаа шидэт дөрвөлжинг хамгийн цөөн үйлдлээр өгсөн хэлбэрт шилжүүлэх програм бич.

ПРОГРАМЫН НЭР: msquare

ОРОЛТЫН ФОРМАТ

Нэг мөрөнд зайгаар тусгаалагдсан 8 тоо байна. 1-ээс 8 хүртэлх тоонуудын сэлгэмэл. Энэ нь таны үүсгэх ёстой хэлбэр юм.

ЖИШЭЭ ОРОЛТ(файл msquare.in)

2 6 8 4 5 7 3 1

ГАРАЛТЫН ФОРМАТ

1-р мөр:	Хамгийн бага хувиргалтын тоог илэрхийлэх нэг бүхэл тоо.
2-оос n мөр:	Хийгдэх хувиргалтуудын дараалал. Хамгийн сүүлийн мөрнөөс бусад мөрөнд 60 тэмдэгт байна.

ЖИШЭЭ ГАРАЛТ (файл msquare.out)

7

ВСАВССВ

Орчуулсан Б.Даваабаяр